

АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Э.БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. “ Аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалт, тайлагналт, хяналт тавьж арга зүйгээр хангах”							
1.1	Арга хэмжээ 1.1. Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналд аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын саналыг хянан, нэгтгүүлэх.	21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн төсөв	21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн 2024 оны батлагдсан төсөв	21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн 2025 оны батлагдсан төсөв	2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийн саналыг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төсвийн удирдамж хүргүүлэх тухай” 01/5374 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу боловсруулж Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны төсвийн төслийг олон нийтэд ил тодоор мэдээлж цахим хэлбэрээр санал асуулга авч Сангийн яаманд 2024.08.19 2/3401 дүгээр албан бичгээр хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн хүргүүлсэн ба 2024.09.26-ны	2024.06.01-12.31	100%

					өдөр Засгийн газрын ордонд нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, Сангийн яам болон олон нийтийн төлөөллийг байлцуулан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 2025 төсвийн төсөлд 21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн 880.5 тэрбум төгрөгийн саналыг авч, боловсруулан нэгтгүүлсэн.		
1.2	Арга хэмжээ 1.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхийг нэмэгдүүлэх хүрээнд 10 аймагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.	10 аймагт байгуулагдсан Нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо	0	10 аймагт нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийн сайдын багцын 2025 оны төсвийн төсөлд тусгуулсан байна.	Эрүүл мэндийн бодлого, удирдлага болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий Нийгмийн эрүүл мэндийн төв 10 аймагт шинээр байгуулахад шаардагдах үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 27.4 тэрбум төгрөгөөр тооцон саналыг Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд эрх зүйн орчин бүрдээгүй тул дэмжигдээгүй. Иймд "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" боловсруулах ажлын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын дагуу өртөг, төлбөрийн аргыг тодорхойлох, дагалдах тооцооллуудыг НЭМГ-ын холбогдох нэгжтэй хамтран боловсруулж, 2024 оны 11 сарын 15-ны өдөр Эрүүл мэндийн яамны сайт дээр тушаалын төслийг байршуулан олон нийтээс санал авч байна.	2024.06.01-12.31	70%

Зорилт 2. “ Аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсөв, санхүүгийн нэгдсэн тооцоолол, судалгаа, дүн шинжилгээ болон нөлөөллийн үнэлгээ хийх”

2.1	Арга хэмжээ 2.1. Аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, удирдлагуудад танилцуулан, эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаа зөвлөмж хүргүүлсэн байна.	2 удаагийн зөвлөмж	0	100%	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд сар бүр эх үүсвэр дутагдаж буй эсэх, өр төлбөр үүссэн эсэх, авлага барагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж нэгжийн удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 1a/267, 1a/1721, 1a/2514, 2/3707, 2/3708, 2/3709, 2/3710 дугаарын албан бичгээр 7 удаа, аман байдлаар хөтөлбөр зориулалтын дагуу төсвийг захиран зарцуулж, төсвийн сахилга баттай ажиллах, мөн 2025 оны төсвийн төслийн саналыг үндэслэл тооцоололтой төлөвлөж ирүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. Тухайлбал: Аймгийн эрүүл мэндийн газрын дарга нарт анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн зарлагыг төлөвлөх, зохицуулах, хуваарилах, санхүүжүүлэхтэй холбоотой чиглэлийг 1a/1721 тоот албан бичгээр хүргүүлсэн. Аймаг, нийслэлийн засаг дарга нарт орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын байр ашиглалтын зардлыг “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу орон нутгийн төсвөөс шийдвэрлэх талаар чиглэлийг 1a/267 тоот албан бичгээр хүргүүлсэн.	2024.01.01-12.31	100%
-----	---	--------------------	---	------	--	------------------	------

23

					Хүн амын тоо бага, олслагдмал санхүүжилт хүндэрсэн 30 сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагатай Сайдтай хийсэн уулзалт хэлэлцүүлгийг ЭМДЕГ-тай хамтран зохион байгуулсан.		
2.2	Арга хэмжээ 2.2. Гүйцэтгэлээр санхүүждэг аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын зардлын төлөвлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сангийн орлоготой уялдуулан програмд оруулсан байна.	Сангийн яамны FISCAL программ ашиглаж байгаа байгууллагын тоо	16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ	100%	Аймгийн 16 нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний 5 төв, 6 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, 7 уламжлалт анагаах ухааны төв, 328 сумын эрүүл мэндийн төвийн зардлын төлөвлөлтийг Эрүүл мэндийн даатгалын сангийн орлоготой уялдуулан Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн FISCAL програмд оруулсан. Эрүүл мэндийн сайдын А/78, А/201, А/429 дүгээр тушаалаар Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй уялдуулан Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны төсвийн хуваарийг баталж, Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Мөн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг авч, Сангийн яам руу 2024.01.03 1а/11, 2024.01.24 1а/332, 2024.01.30 1а/411, 2024.02.29 1а/872, 2024.03.15 1а/1090, 2024.04.01 1а/1289, 2024.04.19 1а/1610, 2024.04.30 1а/1809, 2024.05.27 1а/2245, 2024.05.30 1а/2315, 2024.07.24 1а/3033, 2024.08.02 1а/3169, 2024.08.23 1а/3450, 2024.09.04 1а/3618, 2024.10.14 1а/4183, 2024.11.05 1а/4524, 2024.11.20 1а/4854, 2024.11.25 1а/4948 дугаар албан бичгээр нийт 18 удаа хүргүүлэн шийдвэрлүүлсэн.	2024.01.01-12.31	80%

2.3	Арга хэмжээ 2.3. Аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, санал боловсруулан хүргүүлж, шаардагдах төсвийг нэмж батлуулах.	Албан хаагчдын тоо, төсөв	21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн 2024 оны батлагдсан төсөв	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишиг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 1 удаа санал боловсруулан удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулж, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан байна. Тогтоол гарсантай холбоотойгоор улсын төсвөөс санхүүждэг орон нутгийн 34 байгууллагын 4,335 мянган албан хаагчийн цалингийн зардалд 1,1 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг байгууллагын орон нутгийн байгууллагуудын 28604 мянган албан хаагчийн цалингийн зардалд 152,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, Сангийн яаманд 2024 оны 1а/1289 дүгээр албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ТАЦНС программаар 446 байгууллагын 32,8 мянган эмч, эмнэлгийн ажилтанд 1,1 тэрбум төгрөгийн цалин хөлс олгож хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	2024.01.01-12.31	100%
2.4	Арга хэмжээ 2.4. Аймаг, суманд ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ангилал зэрэглэл харгалзахгүй олгох тооцооллыг хийж санал боловсруулан хүргүүлж, шаардагдах төсвийг нэмж батлуулах.	Албан хаагчдын тоо, төсөв	21 ЭМГ, 13 ЗӨСТ, 16 НЭ, 5 БОЭТ, 6 ХНЭ, 7 УАУТ, 328 СЭМТ-ийн 2024 оны батлагдсан	Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын дагуу орон нутаг ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум /тосгон/-ны 9,011 албан хаагчид тухайн албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвийн 8,402 албан хаагчид тухайн албан тушаалын үндсэн цалингийн 20	2024.01.01-12.31	100%

			төсөв, албан хаагчдын тоо		хувиар тус тус тооцож, нийт 17,413 албан хаагчид 69.8 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн батлуулж, 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.		
2.5	Арга хэмжээ 2.5. Эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарч буй тэтгэмж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтанд олгох тэтгэмжийн санхүүжилтийн тооцооллыг хийж, санхүүжүүлэх, төсвийн зохицуулалт хийх.	ТАЦНС-ээр тэтгэмж авсан хүний тоо, санхүүжилтийн дүн	Тэтгэмжийн санхүүжилт авсан албан хаагчдын тоо, батлагдсан төсөв	Холбогдох хууль, Засгийн газрын тогтоолын дагуу аймаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын тэтгэмжийн санхүүжилтийг олгосон байна.	Эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарч буй тэтгэмж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтанд олгох тэтгэмжийн санхүүжилтийн тооцооллыг хийж, санхүүжилтийн эрх нээлгэх тухай Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.20 2/2124, 204.05.30 2/2316, 2024.01.25 2/355, 2024.02.08 2/554, 2024.03.14 2/1068, 2024.04.11 2/1479, 2024.05.09 2/1980 албан бичгүүдийг Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлэн санхүүжилтийг олгож байна. 2024 оны байдлаар ТАТХ-ийн 60.1, ЭМТХ-ийн 29.2 заалтын дагуу 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид 18.6 тэрбум төгрөгийн, ЭМТХ-ийн 29.5 дахь заалтын дагуу орон нутгийн албан хаагчид 25.4 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.	2024.01.01-12.31	100%
2.6	Арга хэмжээ 2.6. Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг дарга нартай байгуулах 2024 онд хамтран ажиллах гэрээний холбогдох хавсралтыг боловсруулах.	Гэрээний хавсралт	2024 оны батлагдсан төсөв	Аймгийн Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээний хавсралт хүргэгдсэн байна.	Эрүүл мэндийн сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээний төсөв санхүүтэй холбоотой хавсралтыг боловсруулж, Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. 2024 оноос аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны төв,	2024.01.01-02.29	100%

2

Хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн байр ашиглалтын зардлыг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр шийдвэрлүүлсэн.

Зорилт 3. “Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх”

3.1	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг мөрдөж ажиллах, хариутай албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллах.	Гаргасан тушаал, шийдвэрийн тоо Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	Хариуцсан чиг үүрэгт хамаарах албан бичгүүдийг хүлээн авч, цаг хугацаанд нь хурдан шуурхай хариуг төлөвлөж, удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлсэн байна.	Тайлант хугацаанд нийт 355 албан бичиг ирсэн бөгөөд хариутай 55 албан бичгийг хааж, иргэдээс ирүүлсэн 25 өргөдөл гомдолд хариу өгч ажилласан. Эрүүл мэндийн сайдын А/78, А/86, А/110, А/152, А/201, А/252, А/253, А/429, А/483 тушаалыг боловсруулж, батлуулсан.		
3.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын мөрдөж ажиллах, чиг үүрэгт хамаарах баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэж, архивт хүлээлгэн өгөх.	Хадгаламжийн нэгж	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллана.	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны төсвийн төслийн 2 баримтыг үдэж, дугаарлан, ТЗУГ-ын архивын ажилтанд хүлээлгэн өгөв.		
3.3	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Ажлын хэсгийн тушаал, шийдвэрийн дугаар	Ажлын хэсэгт ажилласан тухай бүрэн тайлагнасан байна.	ЭМС-ын 2023 оны А/400 тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, ЭМДҮЗ-ийн 2024 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 05 дугаар тогтоолын тарифыг шинэчлэн тогтоохтой холбоотой судалгаа, тооцооллыг хийсэн.		
3.4	Газар, хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, шаардлагатай тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Ажлын хэсгийн тушаал, шийдвэрийн дугаар	Ажлын хэсэгт ажилласан тухай бүрэн тайлагнасан байна.	Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 12 дугаар тогтоолын дагуу олгох Зоонозын өвчин судлалын төвийн зарим албан хаагчид олгох хөдөлмөрийн		

					нөхцөлийн нэмэгдлийн тооцооллыг хийж, нэмэгдүүлэн батлуулсан. 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.		
Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”							
4.1	“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. Үүнд: Зорилт 1 – 2 ажил Зорилт 2 – 6 Зорилт 3 – 4 Зорилт 4 – 2 ажил хийхээр тус тус төлөвлөсөн байна.	2024.01.01-02.29	100%
4.2	2023 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах.	Мэдүүлгийн дугаар	1	2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж илгээсэн байна.	2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргаж, эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.	2024.01.01-02.29	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах.	2 сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журам	0	1	Журмын төсөл боловсруулагдсан бөгөөд дахин сайжруулалт хийгдэж байна.	2024.01.01-12.31	30%
2.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан 2 үнэлгээний	Үнэлгээний хорооны	0	2	XVIII.3.15 “Эмнэлгийн тоног төхөөрөмж /Хөвсгөл” төсөл арга хэмжээний 4 багц тендерийг нээлттэй тендер	2024.01.01-06.01	100%

хороонд гишүүнээр орж ажилласан. Үүнд: XVIII.3.15 “Эмнэлгийн тоног төхөөрөмж /Хөвсгөл/” төсөл арга хэмжээ XVIII.3.39 “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/” төсөл арга хэмжээ	зөвлөмж, мэдэгдэл		шалгаруулалтын журмаа зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн. XVIII.3.39 “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/” төсөл арга хэмжээний тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн.		
---	-------------------	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдах цахим сургалтад 1-ээс дээш удаа хамрагдах.	Сургалтын тоо	0	2	Удирдлагын академийн “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц” сургалтад хамрагдаж төгссөн. Мөн Төрийн албаны зөвлөл болон Эрүүл мэндийн яамнаас албан хаагч нарт зориулан зохион байгуулсан цахим болон танхимын сургалтуудад хамрагдсан. 1. Төрийн албаны шинэтгэл ба “Цэгцрэх хөдөлгөөн” сэдвээр УИХ-ын дарга Г.Занданшатар; 2. “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдвээр УИХ-ын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа. 3. бүтээмжийн сэргэлт-цахим эрүүл мэнд”	2024.01.01-12.31	100%

90

					4. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг сургалт. 5. Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооноос Монгол Улсын төрийн соёрхолт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич С.Нарангэрэл хуульчийн сургалт 6. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн цалин хөлс /орон нутгийн нэмэгдэл/ сэдэвт цахим сургалт		
2.	Арга хэмжээ 2. Эрхэлсэн ажлынхаа хүрээнд холбогдох хууль, дүрэм журам шинэчлэгдэх бүрд судлан мэдлэгээ дээшлүүлэх.	Хууль, тогтоомжийн тоо	0	2	1. Засгийн газрын 2024 оны 12,82,83,84,128 дугаар тогтоолуудыг уншиж судалсан. 2. ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоол, 06 дугаар тогтоолыг уншиж судалсан.	2024.01.01-12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Аймаг дахь эрүүл мэндийн байгууллагын төсвийн асуудал хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

.....Э.Баярмаа..... / 

(Нэр, гарын үсэг)

2024 12 05

(Огноо)

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС (ЗАГВАР)

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих” журмын төслийн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах.	Төрийн нарийн бичгийн дарга	2 сайдын хамтарсан тушаалаар батлагдсан журам	0	1	01.01	12.31
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан 2 үнэлгээний хороонд гишүүнээр орж ажилласан. Үүнд: 1. XVIII.3.15 “Эмнэлгийн тоног төхөөрөмж /Хөвсгөл” төсөл арга хэмжээ 2. XVIII.3.39 “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг” төсөл арга хэмжээ	Төрийн нарийн бичгийн дарга	Шүүхийн шийдвэр	0	1	03.01	09.30

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР
АВСАН:

CDX -ийн мэдээллийн
(Албан тушаал)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

(Албан тушаал)

Г. Багчаа , Г. Буяа

(Нэр, гарын үсэг)

Мөнхтүвшин , Мөнхтүвшин

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

2024 06 09
(Огноо)